

1. Илтгэгчийн нэр, албан тушаал, зураг, байгууллагын нэр, лого
П.Ариунсүрэн, О.Бүрэнжаргал, Т.Байгал-Амар

ХААИС, Агроэкологийн сургууль, Экологийн тэнхим

2. Илтгэлийн сэдэв, судалгааны ажлын товч үр дүн

Илтгэлийн сэдэв: **Голын эргийн тогтворжуулагч ургамал**

Голын эргийн тогтворжуулагч ургамлын онцлог юу?

Ургамал судлаачид хээрийн ургамалд анхааран, усны экологичид усан доторх ургамалд анхааран яг эргийн бүсийн ургамлын үүрэг, үйл ажиллагаанд анхаарал хандуулах, ач холбогдлыг тодорхойлох асуудал орхигдсон байдаг. Эргийг тогтвортой байлгах ингэснээр үертэй үед урсгалын хүчийг сааруулж, элэгдэл, эвдрэлийг бууруулах, ус татам руу хальж газарт шингэж орчны чийгтэй байх нөхцлийг бүрдүүлдэг үүргийн ихэнхийг тогтворжуулагч ургамлууд гүйцэтгэдэг.

Тогтворжуулагч ургамалд, гол горхи, нуур цөөрмийн захаар ургасан, ихэвчлэн хүчтэй салаалсан үндэсний системтэй, нягт дэгнүүл үүсгэдэг юмуу үндэслэг иштэй, гүн салаалдаг мяндаслаг үндэстэй, том өргөн шугаман навчтай, босоо саглагар титэмтэй үетэн, улалж зэрэг овгийн өвслөг ургамлууд болон бургасны овгийн моднууд орох бөгөөд тэдгээр нь асар том үндэсний системтэй учраас голын эргийг тогтоон барьж, эрэг орчмын усны урсгалын хүчийг сааруулж чаддаг, хаялагаар хуримтлагдсан хурдсыг хамгаалах үүрэг гүйцэтгэдэг, сэргэн ургах чадвартай олон наст ургамлууд юм.

Судалгааны товч үр дүн

Бидний 2018, 2019 онд Тамир голын голын эрэг татамд гүйцэтгэсэн судалгааны үр дүнд **эргийг** тогтворжуулах үүрэгтэй Гурван цэцэгт химдэг (*Glyceria triflora* (Korsh.) Kom.), Судалгүй улалж (*Carex enervis* C.A.Mey), Бут улалж (*Carex caespitosa* L), Намгийн биелэг өвс (*Poa palustris* L), Дорнодын тор өвс (*Beckmannia syzigachne* Steud.), аварга улаан толгой (*Agrostis gigantea* Roth) зүйлийн өвслөг ургамлууд, модноос Тарайкын бургас, лавр навчит улиас зэрэг зүйлүүд нь малын хөлд гишгэгдсэн, идэгдсэн хэвийн ургалттай бус, сэргэн ургалт нь хязгаарлагдмал байдалтай байв.

3. Холбогдох зураг, графикууд



Зураг 1. Эргээрээ тогтворжуулагч ургамлын бүлгэмдэлтэй экосистемийн үйл ажиллагаа нь зохистой нөхцөлд байгаа голууд



Зураг 2. Тогтворжуулагч ургамлын үндэсний систем



Зураг 3. Тогтворжуулагч модлог ургамал эргээ хамгаалж буй байдал

<p><i>Carex enervis</i> С.А.Мей.-Судалгүй улалж</p>	<p><i>Carex caespitosa</i> L.-Бут улалж</p>



Poa palustris L.-Намгийн биелэг өвс



Beckmannia syzigachne (Steud.) Fern.-
Дорнодын тор өвс



Agrostis gigantea Roth.-Аврага улаан



Glyceria triflora (Korsh.) Kom.-Гурван

<i>толгой</i>	<i>цэцэгт химдэг</i>
---------------	----------------------

Зураг 4. Тамир голын цутгал Ангархайн голын эргээрх тогтворжуулагч өвслөг ургамлын зүйлүүд

4. Судалгааны ажлын хураангуй- PDF file